



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2025 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

**Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар
авах зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.5, 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115 дугаар зүйлийн 115.2.14 дэх заалтыг тус тус үндэслэн Ёс зүй, дэгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилт, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн нэгдсэн дүн, төлөв байдлын талаарх Ёс зүйн хорооны 2024 оны тайланг хэлэлцээд дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосугай:

1.1.Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т:

1/Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлыг төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын жил бүрийн төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг ханган үр дүнд хяналт тавьж ажиллах;

2/Монгол хүний сэтгэлгээ, үнэт зүйл, шинжлэх ухааны судалгаанд үндэслэн нийгмийн ёс суртахууныг дээшлүүлэхэд чиглэсэн албан болон албан бус сургалтын хөтөлбөрийн агуулгыг боловсруулан сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж, үр дүнг нэгтгэн жил бүр тайлагнаж ажиллах;

3/Монгол Улсын Ёс зүйн хорооны гишүүдийн, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороодын гишүүдийн хараат бус, бие даасан зарчмаар ажиллах нөхцөл, баталгааг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хангах зохицуулалт хийх.

1.2.Монгол Улсын Ёс зүйн хороо (Ц.Амартөгс)-нд:

1/Төрийн байгууллага, албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийж, нөхцөл байдлыг үнэлж, эрэмбэлэх чиглэлээр арга зүй, аргачлалыг судлан боловсруулж, нэвтрүүлэх;

2/Төрийн албаны ёс зүйн индексийг тодорхойлох асуудлыг судлан санал боловсруулж танилцуулах;

3/Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл болон гомдол, мэдээлэл, зөрчил, хариуцлагын нэгдсэн бүртгэлийн системийг сайжруулж, тогтмол хэрэглээнд хэвшүүлэх.

1.3.Төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтнуудад:

1/Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, тухайн байгууллагын Ёс зүйн дэд хорооны гишүүдэд олгох урамшууллын асуудлыг шийдвэрлэх, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэн үр дүнг тооцож ажиллах.

2.Тогтоолын хэрэгжилтийг ханган Улсын Их Хурлын 2026 оны Хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан Байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т, Монгол Улсын Ёс зүйн хороо (Ц.Амартөгс)-нд үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Ёс зүй, дэгийн байнгын хороо (Б.Баярбаатар)-нд даалгасугай.

ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Б.БАЯРБААТАР